



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/005/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын Дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Ахлах аудитор: Ё.Лхагвадулам
Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyo@audit.gov.mn

Улаанбаатар хот
2025 он

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5	
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд...	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	24
4.1 Ерөнхий зүйл	24
4.2 Материаллаг байдал	24
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	24
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	26
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	27
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох ажил
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УССТ	Усан спорт сургалтын төв
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠒᠐25.03.2᠘

№

01/᠒᠖᠘

танай

-ийг №

-г

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.ЦЭРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан харилцагч 10 аж ахуйн нэгжид олгосон урьдчилгаа 15,267.3 сая төгрөгийн гүйцэтгэлд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

Аудитын гол асуудал

Тайлант онд 517,020.7 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд түүнд 5 удаа тодотгол хийж, 12,667.7 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар нэмэгдүүлэн 529,688.4 сая төгрөгөөр баталжээ. Үйл ажиллагаандаа 491,285.3 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 60.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 108 зорилт, 151 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

15.03.2025

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



[Signature] М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\androm... d:\work\2025\Hw\dt\... \en\hwy0025 08 25 HSD 25.docx

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115,279,426.4	97,077,609.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	87,224,908.4	57,672,034.6
33	АВЛАГА	165,709.0	852,187.8
34	УРЬДЧИЛГАА	3,368,823.8	15,498,570.0
35	БАРАА МАТЕРИАЛ	2,150,300.3	2,406,162.5
36	НӨӨЦИЙН БАРАА	0	204,643.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	22,369,684.8	20,444,011.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	148,744,920.6	234,399,062.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	148,744,920.6	234,399,062.4
39200	Биет хөрөнгө	145,774,533.0	231,354,424.3
39300	Биет бус хөрөнгө	2,970,387.5	3,044,638.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	264,024,346.9	331,476,671.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,065,367.8	9,707,156.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,065,367.8	9,707,156.4
41300	Өглөг	1,604,820.2	3,559,949.6
41400	Урьдчилж орсон орлого	2,460,547.6	6,147,206.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	259,958,979.1	321,769,515.5
51	Засгийн газрын хувь оролцоо	259,958,979.1	321,769,515.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	21,805,055.7	21,805,055.7
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	739,735.0	1,056,003.0
51200	Хуримтлагдсан үр дүн	206,458,340.4	267,971,642.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,955,848.0	30,936,814.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	264,024,346.9	331,476,671.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	377,650,281.90	556,838,083.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	347,752,591.50	444,646,876.60
110	Орлогын албан татвар	272,191,348.90	367,844,561.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	272,191,348.90	367,844,561.20
113	Хөрөнгийн албан татвар	19,615,441.80	26,759,262.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,945,800.70	50,043,052.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,844,141.30	91,323,954.10
120	Нийтлэг татварын бус орлого	25,999,117.90	88,223,335.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,845,023.40	3,100,618.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,053,549.20	20,867,252.50

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	294,454,096.60	453,441,476.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294,454,096.60	453,441,476.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,444,796.40	116,469,904.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,274,152.00	18,277,116.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,573,814.70	2,243,624.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,015,973.60	8,559,139.30
2104	Хангамж, бараа материалын зардал	1,872,358.50	12,087,567.40
2105	Нормативт зардал	6,970.20	80,335.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,038,099.60	7,670,662.70
2107	Томилолт, зочны зардал	673,885.40	669,700.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,313,872.80	41,926,937.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,675,669.70	24,954,820.70
212	ТАТААС	0	292,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	226,009,300.20	336,679,572.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	83,196,185.30	103,396,606.60
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,293,042.00	41,362,860.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	63,903,143.40	62,033,746.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,851,589.7	0.0	194,851,589.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-656,278.6	0.0	-656,278.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	194,195,311.0	0.0	194,195,311.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-29,399.5	0.0	-29,399.5
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,889,924.2	0.0	1,889,924.2
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	63,903,143.4	0.0	63,903,143.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,958,979.1	0.0	259,958,979.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	259,958,979.1	0.0	259,958,979.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-204,175.7	0.0	-204,175.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,754,803.4	0.0	259,754,803.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-19,033.9	0.0	-19,033.9

**Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	62,033,746.0	0.0	62,033,746.0
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	321,769,515.5	0.0	321,769,515.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	357,215,606.0	480,969,688.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	347,752,591.5	444,646,876.6
110	Орлогын албан татвар	272,191,348.9	367,844,561.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	272,191,348.9	367,844,561.2
113	Хөрөнгийн албан татвар	19,615,441.8	26,759,262.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,945,800.7	50,043,052.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,590,266.4	16,523,831.3
1181	Газрын төлбөр	31,333,813.9	33,459,844.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,720.3	59,377.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,409,465.3	15,455,559.5
120	Нийтлэг татварын бус орлого	5,564,442.0	12,354,940.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,845,023.4	3,100,618.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,053,549.2	20,867,252.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285,512,462.0	432,271,552.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,512,462.0	432,271,552.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,385,813.9	95,292,727.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,501,228.4	29,135,956.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,846,091.9	4,625,629.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,585,272.6	9,320,745.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,349,438.2	15,750,986.5
2105	Нормативт зардал	24,252.7	29,066.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,752,431.6	7,207,052.2
2107	Томилолт, зочны зардал	702,681.1	677,263.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,542,959.0	23,454,587.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,081,458.4	5,091,440.4
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	292,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	233,126,648.1	336,686,824.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	71,703,144.0	48,698,136.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	25,310,629.6	78,251,010.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,310,629.6	78,251,010.2
2200	Дотоод эх үүсвэрээр	25,310,629.6	78,251,010.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-25,310,629.6	-78,251,010.2

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	46,392,514.4	-29,552,873.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,832,394.0	87,224,908.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	87,224,908.4	57,672,034.6

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	529,688,422.4	491,285,348.8	38,403,073.6	92.7
УРСГАЛ ЗАРДАЛ	424,386,955.1	415,510,021.2	8,876,933.9	97.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,129,716.3	78,896,642.7	12,233,073.6	86.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,058,834.0	12,750,862.4	1,307,971.6	90.7
Үндсэн цалин	4,600,451.4	4,695,143.1	(94,691.7)	102.1
Нэмэгдэл	2,399,948.4	1,802,303.4	597,645.0	75.1
Унаа хоолны хөнгөлөлт	1,872,586.0	1,527,320.6	345,265.4	81.6
Урамшуулал	1,637,448.2	1,364,000.3	273,447.9	83.3
Гэрээт ажлын хөлс	3,548,400.0	3,362,095.0	186,305.0	94.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,754,817.4	1,461,828.4	292,989.0	83.3
Тэтгэврийн даатгал	1,175,896.9	994,681.8	181,215.1	84.6
Тэтгэмжийн даатгал	140,399.6	126,238.2	14,161.4	89.9
ҮОМШӨ-ний даатгал	97,133.7	63,565.8	33,567.9	65.4
Ажилгүйдлийн даатгал	60,706.7	52,626.4	8,080.3	86.7
Эрүүл мэндийн даатгал	280,680.5	224,716.2	55,964.3	80.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,090,917.4	7,319,372.6	4,771,544.8	60.5
Гэрэл, цахилгаан	3,957,729.5	2,144,085.4	1,813,644.1	54.2
Түлш, халаалт	4,497,486.6	2,714,477.4	1,783,009.2	60.4
Цэвэр, бохир ус	2,880,028.3	1,802,866.7	1,077,161.6	62.6
Байрны түрээс	755,673.0	657,943.2	97,729.8	87.1
Хангамж, бараа материалын зардал	16,161,095.0	15,743,206.9	417,888.1	97.4
Бичиг хэрэг	260,099.4	239,450.9	20,648.5	92.1
Тээвэр, шатахуун	164,080.0	151,060.0	13,020.0	92.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	264,160.0	219,945.6	44,214.4	83.3
Ном, хэвлэл	76,343.9	62,211.0	14,132.9	81.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,956,055.8	14,669,957.6	286,098.2	98.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	440,355.9	400,581.7	39,774.2	91.0
Нормативт зардал	17,880.0	2,899.7	14,980.3	16.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,200.0	899.7	300.3	75.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,680.0	2,000.0	14,680.0	12.0
Эд хогшил, урсгал засварын зардал	2,885,681.2	2,787,453.9	98,227.3	96.6
Багаж, техник, хэрэгсэл	389,383.3	347,408.7	41,974.6	89.2
Тавилга	266,273.7	238,614.3	27,659.4	89.6
Урсгал засвар	2,230,024.2	2,201,430.9	28,593.3	98.7
Томилолт, зочны зардал	1,009,665.8	667,235.7	342,430.1	66.1
Гадаад албан томилолт	847,465.8	596,488.5	250,977.3	70.4
Дотоод албан томилолт	34,000.0	6,103.6	27,896.4	18.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	128,200.0	64,643.6	63,556.4	50.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,719,546.7	33,950,975.8	4,768,570.9	87.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,417,291.2	33,677,758.3	4,739,532.9	87.7
Даатгалын үйлчилгээ	18,600.0	13,406.8	5,193.2	72.1
Тээврийн хэрэгслийн татвар	14,250.0	2,187.5	12,062.5	15.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	750.0	-	750.0	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	146,160.0	135,493.1	10,666.9	92.7

**Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Газрын төлбөр	122,495.5	122,130.2	365.3	99.7
Бараа үйлчилгээний бусад зардал	4,431,278.8	4,212,807.3	218,471.5	95.1
Бараа үйлчилгээний бусад зардал	4,407,278.8	4,195,369.3	211,909.5	95.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,000.0	17,438.0	6,562.0	72.7
ТАТААС	292,875.1	292,000.0	875.1	99.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	292,875.1	292,000.0	875.1	99.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	292,875.1	292,000.0	875.1	99.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	332,964,363.7	336,321,378.5	(3,357,014.8)	101.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	330,694,428.9	334,139,520.4	(3,445,091.5)	101.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	330,694,428.9	334,139,520.4	(3,445,091.5)	101.0
Бусад урсгал шилжүүлэг	2,269,934.8	2,181,858.1	88,076.7	96.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,870.0	15,452.5	2,417.5	86.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	271,184.8	223,109.9	48,074.9	82.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,980,880.0	1,943,295.7	37,584.3	98.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,301,467.3	75,775,327.6	29,526,139.7	72.0
Дотоод эх үүсвэрээр	105,301,467.3	75,775,327.6	29,526,139.7	72.0
Барилга байгууламж	34,315,666.0	30,433,152.3	3,882,513.7	88.7
Тоног төхөөрөмж	15,574,230.9	13,002,032.1	2,572,198.8	83.5
Бусад хөрөнгө	55,411,570.4	32,340,143.2	23,071,427.2	58.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	529,688,422.4	490,940,876.0	38,747,546.4	92.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,237,726.7	3,100,618.7	137,108.0	95.8
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	3,237,726.7	3,100,618.7	137,108.0	95.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	480,296,538.3	487,300,213.7	(7,003,675.4)	101.5
Орон нутгийн төсвөөс	480,296,538.3	487,300,213.7	(7,003,675.4)	101.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	46,154,157.4	540,043.7	45,614,113.7	1.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	688,237.9	540,043.7	148,194.2	78.5
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	45,465,919.5	-	45,465,919.5	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,753,024.8	(2,753,024.8)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,408,552.0	(2,408,552.0)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,152	1,116	36	96.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8	-	100.0
Төсвийн байгууллага	8	8	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	572	554	18	96.9
Удирдах ажилтан	51	47	4	92.2
Гүйцэтгэх ажилтан	210	207	3	98.6
Үйлчлэх ажилтан	306	295	11	96.4
Гэрээт ажилтан	5	5	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	572	554	18	96.9
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	175	169	6	96.6
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6	6	-	100.0
Соёл урлагийн салбарын төрийн йлчилгээний албан хаагч (ТҮСУ)	13	12	1	92.3
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	341	330	11	96.8
Гэрээт ажилтан	5	5	-	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	32	32	-	100.0

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,082,092.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,082,092.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,792,853.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	819,702.5
210301	Гэрэл, цахилгаан	819,702.5
2104	Хангамж, бараа материалын зардал	14,925,353.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,925,353.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	568,670.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,259.6
210602	Тавилга	19,000.0
210604	Урсгал засвар	523,410.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,680,977.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,680,977.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	798,150.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	798,150.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	289,238.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	270,326.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	243,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,326.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,912.6
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	18,912.6
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,082,092.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,082,092.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,345,021.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	537,071.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Хан-Уул дүүрэг нь эрхэм зорилгоо “Хариуцлагатай, мэргэшсэн, нэгдмэл хамт олныг төлөвшүүлж, нийгмийн хэрэгцээ, тэгш байдлыг хангасан бодлогыг төлөвлөн хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод байдлыг дээшлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах 5 бүлэг зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана гэж тодорхойлжээ. Үүнд:

- “Эко дүүрэг-Ногоон хөгжил” бүлэг (4 зорилго, 16 зорилт, 25 арга хэмжээ)
- “Эрүүл дүүрэг-Хүний хөгжил” бүлэг (4 зорилго, 20 зорилт, 36 арга хэмжээ)
- Төрийн үйлчилгээг-Иргэн бүрд” бүлэг (4 зорилго, 15 зорилт, 18 арга хэмжээ)
- “Нийгмийн хөгжил-Өрх бүрд” бүлэг (5 зорилго, 29 зорилт, 38 арга хэмжээ)
- “Дэд бүтцийн хөгжил-Хороо бүрд” бүлэг (6 зорилго, 28 зорилт, 34 арга хэмжээ).

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Хан-Уул дүүргийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга);
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга);
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоол “Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаал “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба нь Дотоод аудитын хорооны баталсан 2024 оны аудит, хяналт шалгалт, зөвлөн туслах ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 23 байгууллагад санхүүгийн хяналт төлөвлөж, төлөвлөгөөний дагуу шалгалтыг бүрэн хэрэгжүүлж, 1 байгууллагад төлөвлөгөөт бус, нийт 24 байгууллагад аудитыг гүйцэтгэжээ. Аудитаар нийт 1,716,576.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1,244,889.6 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 471,68.7 мянга төгрөгийн 178 зөвлөмж өгсөн бөгөөд албан шаардлага 100 хувь, зөвлөмж 96 хувьтай тус тус хэрэгжсэн гэж тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус дүүргийн Засаг даргын харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,452,325.0 мянган төгрөгөөр буюу 25.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	87,224,908.4	57,672,034.6	(29,552,873.8)
Авлага	165,709.0	852,187.8	686,478.8
Урьдчилгаа	3,368,823.8	15,498,570.0	12,129,746.2
Бараа материал	2,150,300.3	2,406,162.5	255,862.2
Нөөцийн бараа	0.0	204,643.0	204,643.0
Бусад эргэлтийн хөрөнгө	22,369,684.8	20,444,011.6	(1,925,673.2)
Үндсэн хөрөнгө	148,744,920.6	234,399,062.4	85,654,141.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	264,024,346.9	331,476,671.9	67,452,325.0
Өр төлбөр	4,065,367.8	9,707,156.4	5,641,788.6
Засгийн газрын хувь оролцоо	259,958,979.1	321,769,515.5	61,810,536.4
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	264,024,346.9	331,476,671.9	67,452,325.0

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, нөөцийн бараа, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцооны данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 57,672,034.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 29,552,873.8 мянган төгрөгөөр буюу 33.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	77,718,927.8	54,233,904.8	23,485,023.0
Төгрөг	2,358.3	236.4	2,121.9
Кассад байгаа бэлэн мөнгө	2,358.3	236.4	2,121.9
Төрийн сангийн харилцах	76,743,070.1	50,337,021.0	26,406,049.1
Арилжааны банк дахь харилцах	975,857.7	3,896,883.8	(2,921,026.1)
Замд яваа мөнгөн хөрөнгө	9,503,622.3	3,437,893.4	6,065,728.9
Дүн	87,224,908.4	57,672,034.6	29,552,873.8

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Кассад байгаа бэлэн мөнгөнд Хан-Уул агро ОНӨААТҮГ-ын 3.3 мянган төгрөг, Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 223.3 мянган төгрөг, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын 9.8 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнажээ.

Төрийн сангийн харилцах дансанд 50,337,021.0 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь орон нутгийн ерөнхий орлогын дансны 47,725,849.3 мянган төгрөг, дүүргийн ОНӨААТҮГ-уудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,897,120.2 мянган төгрөг, дүүргийн хөрөнгө оруулалтын барьцаа 3,426,404.3 мянган төгрөг, ОНХС-ийн 2,408,552.0 мянган төгрөг, байгаль хамгаалах сангийн 214,108.8 мянган төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Арилжааны банк дахь харилцах дансанд 3,896,883.8 мянган төгрөгийн (Зам засвар арчлалт ОНӨААТҮГ-ын 498,968.7 мянган төгрөг, Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 262,854.1 мянган төгрөг, Хан Эко тээвэр ОНӨААТҮГ-ын 58,792.0 мянган төгрөг, Тохжилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 1,626,909.9 мянган төгрөг, Хан-Уул агро ОНӨААТҮГ-ын 526,405.1 мянган төгрөг, Хан-Уул яармаг ОНӨААТҮГ-ын 152,650.5 мянган төгрөг, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын 35,271.0 мянган төгрөг, Эко хотын тээвэр ОНӨААТҮГ 735,032.5 мянган төгрөг) үлдэгдэлтэй байна.

Арилжааны банкны "0" үлдэгдэлтэй төсвийн орлогын харилцах данснаас гүйлгээ хаагдсаны дараа татварын 3,437,893.4 мянган төгрөгийн орлого дүүргийн төрийн сангийн орлогын ерөнхий дансанд 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр он дамжиж орсон тул замд яваа мөнгөн хөрөнгөөр тайлагнажээ.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан байна. (ИТХ 44, 100.0 мянган төгрөг, УССТ 65,550.0 мянган төгрөг, Хан-Уул агро ОНӨААТҮГ 87,309.0 мянган төгрөг, Эко хотын тээвэр ОНӨААТҮГ 322,821.2 мянган төгрөг, Тохжилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 4,015.5 мянган төгрөг, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ 4,928.1 мянган төгрөг, Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ 124,704.5 мянган төгрөг)
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагуудын тухайлбал дүүргийн Татварын хэлтэс, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны болон засварын зардлыг санхүүжүүлсэн байна. (ЗДТГ 280,878.8 мянган төгрөг)
- Төсвийг зориулалт бус, үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна. (Хан-Уул агро ОНӨААТҮГ 1,000.0 мянган төгрөг, УССТ 200.0 мянган төгрөг)

- Татварын цахим системд борлуулалтыг үнэн зөв бүртгэж шивээгүйгээс татварын тайлан буруу алдаатай тайлагнасан байна. (Хан-Уул шинэ өргөө ОНӨААТҮГ 47,612.4 мянган төгрөг)
- Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх үйл ажиллагааны чиглэлд дурдсанаас өөр төрлийн үйлчилгээ авсан байна.(ЗДТГ)

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 852,187.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 686,478.8 мянган төгрөгөөр буюу 4.1 дахин өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	5,950.0	6,333.2	383.2
Дансны авлага /ТӨҮГ/	46,134.0	387,224.5	341,090.5
Татвар, НДШ-ын авлага	76,233.6	365,113.0	288,879.4
Байгууллагаас авах авлага	3,332.0	72,143.1	68,811.1
Хувь хүмүүсээс авах авлага	34,059.4	21,374.0	(12,685.4)
Дүн	165,709.0	852,187.8	686,478.8

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, авлагыг барагдуулаагүй, авлагын үлдэгдлийн тооцоог хийж, баталгаажуулаагүй 10,350.5 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас давхардуулан шилжүүлж үүссэн 34,733.0 мянган төгрөг, Зам засвар арчлалт ОНӨААТҮГ-ын НӨАТ-ын авлага 224,146.2 мянган төгрөг, эдгээр авлага нь нийт авлагын 31.6 хувийг эзэлж байна.

Авлага дансны үлдэгдэлд 812,199.9 мянган төгрөгийн (Зам засвар арчлалт ОНӨААТҮГ 326,313.3 мянган төгрөг, Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ 279,019.3 мянган төгрөг, Хан Эко тээвэр ОНӨААТҮГ 1,534.8 мянган төгрөг, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 140,323.4 мянган төгрөг, Хан-Уул агро ОНӨААТҮГ 6,163.2 мянган төгрөг, Хан-Уул яармаг ОНӨААТҮГ 42,561.1 мянган төгрөг, Эко хотын тээвэр ОНӨААТҮГ 17,284.8 мянган төгрөг) үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд 10,350.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. (Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ)
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 23,342.1 мянган төгрөгийн цалин хөлс алдаатай тайлагнасан байна.(Хан-Уул яармаг ОНӨААТҮГ)

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 15,498,570.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,129,746.2 мянган төгрөгөөр буюу 3.6 дахин өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3,368,823.8	15,498,570.0	12,129,746.2
Дүн	3,368,823.8	15,498,570.0	12,129,746.2

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас гэрээ байгуулж, харилцагч 10 байгууллагад олгосон урьдчилгаа 15,267,299.7 мянган төгрөг, Зам засвар арчлалт ОНӨААТҮГ гэрээт ажлын урьдчилгаанд 125,461.7 мянган төгрөг, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ түрээсийн төлбөрийг урьдчилж төлсөн 19,000.0 мянган төгрөг, Хан эко тээвэр ОНӨААТҮГ эрсдэлийн менежментийн зөвлөгөө сургалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын сургалт, үр нөлөөтэй бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай нэгдсэн стратегийн сургалтуудын төлбөрийн урьдчилгаа 32,600.0 мянган төгрөг, ЗДТГ-аас Эко ахмадын сувиллын цахилгаан дамжуулах ажлын хөлсийг Нүнжиг ХХК-д шилжүүлсэн 54,208.6 мянган төгрөгийн урьдчилгааг бүртгэсэн байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 2,610,805.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 460,505.2 мянган төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн байна.

Бараа материал дансны 23.7 хувь нь Хан-Уул Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т, 13.8 хувь нь Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-т, 11.9 хувь нь ЗДТГ-т, 9.8 хувь нь Зам засвар арчлалт ОНӨААТҮГ-т, 8.9 хувь нь Эко хотын тээвэр ОНӨААТҮГ-т, 7.9 хувь нь Хан Эко тээвэр ОНӨААТҮГ-т, 6.6 хувь нь Хан-Уул агро ОНӨААТҮГ-т тус тус бүртгэлтэй байна. Бусад нөөц дансанд давс бодисын үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	262,214.6	261,047.87	-1,166.8
Эм боох материал	32.5	128.75	96.2
Бичиг хэргийн материал	63,678.0	69,973.84	6,295.9
Аж ахуйн материал	192,486.2	267,660.37	75,174.2
Сэлбэг хэрэгсэл	187,048.9	366,242.58	179,193.7
Түлш, шатах тослох материал	46,755.7	94,343.70	47,588.1
Барилгын засварын материал	378,242.3	258,105.61	-120,136.7
Бусад хангамжийн материал	1,019,842.1	1,088,659.79	68,817.7
Бусад нөөц		204,643.00	204,643.0
Дүн	2,150,300.3	2,610,805.5	460,505.2

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын данс нь худалдан авсан 15,763,974.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 370,269.9 мянган төгрөг, нийт 16,134,244.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаандаа зарцуулсан 15,656,539.3 мянган төгрөг, байгууллага хооронд шилжүүлсэн 17,199.7 мянган төгрөг, нийт 15,673,739.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг хувааж 812,304.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн байна. (Эко хотын тээвэр ОНӨААТҮГ 424,252.3 мянган төгрөг, Хан Эко тээвэр ОНӨААТҮГ 388,051.9 мянган төгрөг)
- Бараа материалын тодруулга тайланд 298.9 мянган төгрөгийн зарцуулсан бараа материалыг шилжүүлснээр тайлагнасан байна. (Хан-Уул яармаг ОНӨААТҮГ)
- Хяналтын тооллогоор дутсан 4,500.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг шийдвэрлээгүй байна.(ИТХ)
- Тогтоосон нормоос илүү шатахуун олгосон, анхан шатны баримтын бүрдэл дутуу 27,075.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. (ИТХ 20,329.3 мянган төгрөг, ЗДТГ-6,745.9 мянган төгрөг)

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 20,444,011.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,925,673.2 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	22,369,684.8	20,444,011.6	(1.925.673.2)
Дүн	22,369,684.8	20,444,011.6	(1.925.673.2)

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэхүү дансанд 4,446,794.6 мянган төгрөгийн барилгын ажил, 1,603,695.0 мянган төгрөгийн тохижилт, засварын ажил, 11,737,842.2 мянган төгрөгийн авто зам, замын байгууламжийн ажил, 289,273.6 мянган төгрөгийн зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, 1,340,110.7 мянган төгрөгийн дэд бүтцийн ажил, 663,665.0 мянган төгрөгийн газар чөлөөлөлт нөхөн олговор, 362,630.5 мянган төгрөгийн хороодын камержуулах ажлыг бүртгэсэн байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 234,399,062.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 85,654,141.8 мянган төгрөгөөр буюу 57.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	145,774,533.1	231,354,424.3	85,579,891.2
Барилга, байгууламж, орон сууц	32,391,955.0	36,060,173.5	3,668,218.5
Авто-тээврийн хэрэгсэл	10,671,038.6	10,713,355.1	42,316.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,753,730.1	3,541,577.8	787,847.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	847,083.4	986,906.4	139,823.0
Бусад үндсэн хөрөнгө	13,736,594.3	22,695,596.4	8,959,002.1
Зам гүүрний байгууламж	85,315,738.9	157,296,612.3	71,980,873.4
Ном	58,392.8	60,202.8	1,810.0
Биет бус хөрөнгө	2,970,387.5	3,044,638.1	74,250.6
Программ хангамж	90,043.4	86,133.4	-3,910.0
Бусад биет бус хөрөнгө	2,880,344.1	2,958,504.7	78,160.6
Дүн	148,744,920.6	234,399,062.4	85,654,141.8

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн худалдан авалтаар 1,278,511.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 106,775,570.0 мянган төгрөг, нийт 108,054,081.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 911,601.4 мянган төгрөг, байгууллага хооронд шилжүүлсэн 2,498,566.6 мянган төгрөг, нийт 3,410,168.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна. Тайлант онд 18,559,339.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Аудитын илрүүлэлт:

- Тушаал шийдвэргүйгээр 58,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. (Эко хотын тээвэр ОНӨААТҮГ)
- Ашиглагч байгууллагад шилжсэн 3,969 м.кв газрыг бүртгэлээс хасаагүй, 2,177.6 м.кв 4 газрын гэрчилгээний болон санхүүгийн тайлан бүртгэл дэх хэмжээ зөрүүтэй байна. (ЗДТГ)
- Тайланд онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн (386,444.6 мянган төгрөг) үнийг шинэчлэн тогтоолгох хүсэлтийн эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлээгүй байна. (Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ)

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,707,156.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,641,788.6 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	1,604,820.2	3,559,949.6	1,955,129.4
Ажилчидтай холбогдсон өглөг	11,657.6	2,009.2	-9,648.4
Байгууллагад төлөх өглөг	1,298,964.2	3,448,815.8	2,149,851.6
Татварын өглөг /ТӨҮГ/	240,455.2	88,406.4	-152,048.8
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.0	1,112.9	1,112.9
Хувь хүмүүст төлөх өглөг	383.5	0.0	-383.5
Дансны өглөг /ТӨҮГ/	53,359.7	19,605.3	-33,754.4
Урьдчилж орсон орлого	2,460,547.6	6,147,206.8	3,686,659.2
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	5,199.7	0.0	-5,199.7
Бусад урьдчилж орсон орлого	2,455,347.9	6,147,206.8	3,691,858.9
Дүн	4,065,367.8	9,707,156.4	5,641,788.6

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансанд хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан 3,426,404.3 мянган төгрөг, Хан-уул яармаг ОНӨААТҮГ-ын 20,240.8 мянган төгрөг, Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 14,974.7 мянган төгрөг, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын 2,600.0 мянган төгрөг, ЗДТГ-ын 340.0 мянган төгрөг, нийт 9,707,156.4 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан байна.

Урьдчилж орсон орлого дансанд Хан Эко тээвэр ОНӨААТҮГ-ын 2,540,336.9 мянган төгрөг, Эко хотын тээвэр ОНӨААТҮГ-ын 1,295,007.9 мянган төгрөг, Хан-Уул агро ОНӨААТҮГ-ын 1,171,895.0 мянган төгрөг, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 1,139,967.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Хүүхэд асрах чөлөөтэй 1 ажилтны нийгмийн даатгалын 2,640.0 мянган төгрөгийг тайлагнаагүй байна.(ИТХ)
- НӨАТ-ийн тайланд 921.4 мянган төгрөгийн орлогыг илүү тусган тайлагнасан байна.(Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ)

3.4.8 Засгийн газрын оролцоо

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 321,769,515.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 61,810,536.4 мянган төгрөгөөр буюу 23.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	21,805,055.7	21,805,055.7	(0.0)
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	21,805,055.7	21,805,055.7	(0.0)
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	739,735.0	1,056,003.0	316,268.0
Хуримтлагдсан үр дүн	206,458,340.4	267,971,642.7	61,513,302.3
Өмнөх үеийн үр дүн	142,555,197.0	205,937,896.7	63,382,699.7
Тайлант үеийн үр дүн	63,903,143.4	62,033,746.0	(1,869,397.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,955,848.0	30,936,814.1	(19,033.9)
Дүн	259,958,979.1	321,769,515.5	61,810,536.4

Эх сурвалж: Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 321,769,515.5 мянган төгрөг болж, 61,810,536.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дүүргийн ТТЗ-ийн 2024 оны төсвийн төсөлд дүүргийн орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 517,020,722.1 мянган төгрөг, нийслэлд төвлөрүүлэх орлогын хэмжээг 337,479,264.2 мянган төгрөг, орон нутгийн төсвийн байгууллагуудын урсгал зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 65,472,710.2 мянган төгрөг, орон нутгийн өмчийн байр ашиглалтын тогтмол зардлыг санхүүжүүлэх эс үүсвэрийг 11,342,015.0 мянган төгрөг, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 96,889,802.2 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 5,836,930.5 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг дүүргийн ИТХ-аар хэвээр баталсан байна.

Дүүргийн орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 517,020,722.1 мянган төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 210,752,595.6 мянган төгрөгөөр буюу 68.8 хувиар нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2023 оны “Дүүргийн 2024 оны орон нутгийн төсөв батлах тухай” 26 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 467,782,649.4 мянган төгрөг, өөрийн орлогыг 688,237.9 мянган төгрөг, ОНХС-ийн санхүүжилтийг 3,083,915.3 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 45,465,919.5 мянган төгрөг, нийт 517,020,722.1 мянган төгрөгөөр, үүнээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 337,479,264.2 мянган төгрөг, төсвийн нийт зарлагыг 179,541,457.9 мянган төгрөг, төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Нийслэлийн 2024 оны төсөвт өөрчлөлт орсонтой холбоотойгоор дүүргийн төсөвт өөрчлөлт оруулан дүүргийн ИТХ-ын 2024 оны “Дүүргийн 2024 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 26 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 480,296,538.3 мянган төгрөг, өөрийн орлогыг 688,237.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 45,465,919.5 мянган төгрөг, ОНХС-ийн санхүүжилтийг 3,237,726.7 мянган төгрөг, нийт 529,688,422.4 мянган төгрөгөөр, үүнээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 330,694,428.9 мянган төгрөг, төсвийн нийт зарлагыг 198,993,993.5 мянган төгрөг, төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Тайлант онд 484,216,801.9 мянган төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 456,651,092.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 5.7 хувиар дутуу биелүүлсэн байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр нь задлан авч үзвэл 153,550,474.2 мянган төгрөг буюу 99.3 хувь нь хууль тогтоомжийн дагуу дүүргийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогын эх үүсвэрээс, 3,100,618.7 мянган төгрөг буюу 0.7 хувь нь дүүрэгт хуваарилах орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлогоос тус тус бүрдэж байна.

Хүснэгт 10. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	484,216,801.9	456,651,092.9	(27,565,709.0)	94.3
УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	480,984,776.2	453,550,474.2	(27,434,302.0)	94.3
I. Татварын орлого	477,255,338.3	444,646,876.7	(32,608,461.6)	93.2
Орлогын албан татвар	374,725,752.8	367,844,561.2	(6,881,191.6)	98.2
1.1.ХХОАТ	374,725,752.8	367,844,561.2	(6,881,191.6)	98.2
1.2.Үйл ажиллагааны орлогын албан татвар	20,200,000.0	19,806,570.4	(393,429.6)	98.1
1.3.Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогын албан татвар	17,680,000.0	26,090,222.5	8,410,222.5	147.6
1.4. Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	28,000,000.0	36,308,622.4	8,308,622.4	129.7
1.5 Цалин хөлс шагнал урамшуулал	271,658,357.0	249,096,958.3	(22,561,398.7)	91.7
1.6 Шууд бус орлого /Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар /	37,187,395.8	36,542,187.6	(645,208.2)	98.3
2. Өмчийн татвар	25,652,920.0	26,759,262.6	1,106,342.6	104.3
2.1 Үл хөдлөх эд хөрөнгийн татвар	25,555,000.0	26,654,179.8	1,099,179.8	104.3
2.2 Малын тоо толгойн татвар	-	2,266.5	2,266.5	
2.3 Бууны албан татвар	97,920.0	102,816.4	4,896.4	105.0
3. Бусад татвар	76,876,665.5	50,043,052.9	(26,833,612.7)	65.1

**Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

3.1.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	163,200.0	245,579.5	82,379.5	150.5
3.2.Улсын тэмдэгтийн хураамж	36,442,665.5	13,299,404.2	(23,143,261.3)	36.5
3.3 Ус, рашаан ашигласны төлбөр	40,800.0	59,377.1	18,577.1	145.5
3.4 Газрын төлбөр	37,300,000.0	33,459,844.5	(3,840,155.5)	89.7
3.5 Хог хаягдлын хураамж	2,930,000.0	2,978,847.5	48,847.5	101.7
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,729,437.9	8,903,597.6	5,174,159.7	238.7
2.2.Хүү торгуулийн орлого	3,000,000.0	8,321,558.1	5,321,558.1	277.4
2.3.Төсөвт газрын өөрийн орлого	688,237.9	540,043.7	(148,194.2)	78.5
2.4.Бусад нэр заагдаагүй орлого	41,200.0	41,995.8	795.8	101.9
Тусламжийн орлого	3,232,025.7	3,100,618.7	3,232,025.7	95.9
Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг	3,232,025.7	3,100,618.7	3,232,025.7	95.9

Орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн нь дараах шалтгаантай байна.

Татварын удирдлагын нэгдсэн санд 2024 онд бүртгэгдсэн 3,652 аж ахуйн нэгж, байгууллагаас цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод 367,844,561.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 4,516,920.0 мянган төгрөгийн ногдуулалттай 88 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэртээ буюу өөр дүүрэг, хөдөө орон нутаг руу шилжсэн нь энэ төрлийн орлогын төлөвлөгөө тасалдахад нөлөөлсөн байна.

Үл хөдлөх хөрөнгийн зөвшөөрөл, зориулалт зөрүүтэй байх, УБЕГ-аас үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ олгоогүй байх, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний гүйцэтгэлийн хувь, бодит гүйцэтгэл зөрөх, үл хөдлөх хөрөнгийг зээлийн барьцаанд тавьснаас шалтгаалан татвар төлөгчийг тодорхойлоход хүндрэл үүсэж байгаатай холбоотой газрын төлбөр төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Хан-Уул дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шилжиж ирсэнтэй холбоотойгоор 2024 оны улсын тэмдэгтийн хураамжийн жилийн төлөвлөгөөг нэмж баталсан боловч 2024 оны 11 сарын 01-ний өдрөөс байршил өөрчлөгдөн Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжсэн нь улсын тэмдэгтийн хураамжийн биелэлтэд нөлөөлсөн байна.

Өөрийн орлогын биелэлтэд 2024 оны 10 дугаар сараас Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын цахилгааны хүчдэл унасны улмаас халаалт зогссон, амрагчид авч үйл ажиллагааг хэвийн явуулаагүй нь нөлөөлсөн байна.

3.5.3 Дүүргийн төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 12,667,700.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 18 хөтөлбөрийн 35 арга хэмжээг улсын төсвөөс 3,237,726.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 480,296,538.3 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 688,237.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 45,465,919.5 мянган төгрөг, нийт 529,688,422.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,100,618.7 мянган төгрөг, улсын төсвөөс 487,300,213.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 540,043.7 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Нийслэлд төвлөрүүлэх орлогыг 330,694,428.9 мянган төгрөгөөр төлөвлөснийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 491,285,348.8 мянга төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 8,876,933.9 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 29,526,139.7 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлж, зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	4,292,457.0	3,903,143.4	389,313.7	90.9
2	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	359,831,132.1	356,541,373.1	3,289,759.1	99.1
3	70418 Худалдан авах ажиллагаа	613,300.8	451,520.9	161,779.9	73.6
4	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	675,344.2	604,375.1	70,969.1	89.5
5	70501 Орон нутгийн төсөвт олгох шилжүүлэг	5,990,741.9	3,445,091.5	2,545,650.4	57.5
6	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	99,310,725.4	75,775,327.6	23,535,397.8	76.3
7	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	592,647.5	529,842.0	62,805.5	89.4
8	71502 Хот байгуулалт, тохижилт	41,913,150.1	38,305,914.9	3,607,235.2	91.4
9	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	940,500.0	663,602.0	276,898.0	70.6
10	71701 Биеийн тамир спорт	1,402,734.7	1,131,904.7	270,830.0	80.7
11	71702 Соёл урлаг	1,238,197.2	1,013,100.2	225,097.0	81.8
12	71801 Сургуулийн өмнөх боловсрол	4,887,525.0	3,015,331.2	1,872,193.8	61.7
13	71802 Ерөнхий боловсрол	6,056,139.0	4,039,392.6	2,016,746.4	66.7
14	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	178,872.0	178,829.8	42.2	100.0
15	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	762,871.4	722,208.6	40,662.8	94.7
16	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	360,209.0	360,209.0	0.0	100.0
17	71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт	292,875.1	292,000.0	875.1	99.7
18	70403 Бүх шатны сонгууль зохион байгуулалт	349,000.0	312,182.4	36,817.6	89.5
19	Нийт	529,688,422.4	491,285,348.8	38,403,073.6	92.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 20,345,021.3 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын нөөц сангаас 200,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 537,071.2 мянган төгрөг, нийт 21,082,092.5 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01/1398 дугаар албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хариуцаж байсан хот нийтийн тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээний зарим чиг үүргийг дүүрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор Нийслэлийн ЗДТГ-аас 19,379,931.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 819,702.5 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 14,925,353.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 568,670.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд

3,680,977.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 798,150.7 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 270,326.1 мянган төгрөг, нийт 21,063,179.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 18,912.6 мянган төгрөгийг дүүргийн төрийн сангийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 14,925,353.0 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, гэрэлтүүлгийн болон урсгал засвар, тохижилтын зардалд 4,453,005.8 мянган төгрөг, ЗДТГ (Гамшгийн үеийн аюултай нөхцөл байдлыг арилгах дайчилгааны зардалд 204,000.0 мянган төгрөг, хороодын хэсгийн ахлагч нарын туршлага судлах зардалд 196,320.0 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн гудамж талбайд иргэд, хүүхэд залуучуудад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, гэрэлтүүлэг бүхий талбайг тохижуулах, тайлан ажилтны алдар талбайд сүлд мод угсарч байршуулсан, ойр орчмын талбай, гүүрэн байгууламжийн гэрэлтүүлэг чимэглэлийн зардалд 150,000.0 мянган төгрөг, урамшууллын зардалд 67,841.7 мянган төгрөг, өвөлжилтийн бэлтгэл хангах, малчин мал бүхий иргэдэд дэмжлэг үзүүлэх зардалд 50,000.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд 45,259.6 мянган төгрөг, геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллого хийх зардалд 29,208.8 мянган төгрөг, Монгол цэргийн өдөр чуулга уулзалтын зардалд 19,500.0 мянган төгрөг, эргэлтийн хөрөнгө авах зардалд 10,414.4 мянган төгрөг, зам талбайн тохижилтын зардалд 4,900.0 мянган төгрөг, мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны ажлын зардалд 3,500.0 мянган төгрөг) 780,944.5 мянган төгрөг, ИТХ (дүүргийн ерөнхий орлогын дансанд хүү торгуулийн орлого төвлөрүүлсэн 451,964.0 мянган төгрөг, цагаатгалын нөхөн олговорт 243,000.0 мянган төгрөг, гэмт хэрэг, хар тамхи мансууруулах бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар хэвлэмэл тараах материал, цуврал контент хийлгэх зардалд 60,250.0 мянган төгрөг, өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн зардалд 19,900.0 мянган төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч болон эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулах зардалд 19,900.0 мянган төгрөг, хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтсан "Гэрэл асаа" аяны зардалд 19,900.0 мянган төгрөг, аюулгүй хороо аяны зардалд 15,500.0 мянган төгрөг, хувь хүний хөгжил, сэтгэлзүй, харилцааны мэдлэг олгох сургалтын зардалд 11,067.4 мянган төгрөг, "Хяналт" тусгай арга хэмжээний зардалд 10,350.0 мянган төгрөг, Шүүхийн үйл ажиллагаатай танилцах өдөрлөг зохион байгуулах зардалд 10,074.0 мянган төгрөг, галын аюулгүй байдлын тухай хууль зөрчих, болзошгүй гамшгийн аюулаас өөрийгөө хамгаалах сургалтын зардалд 8,823.0 мянган төгрөг, зүрхээрээ сонсьё аяны зардалд 5,200.0 мянган төгрөг, ногоон гэрэл-цагаан шугам 2024 тэмцээний зардалд 5,190.6 мянган төгрөг, хөрөнгө худалдан авах зардалд 3,845.0 мянган төгрөг) 884,964.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.5 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2024 оны "Дүүргийн 2024 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай" 26 дугаар тогтоолоор он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 56 төсөл, арга хэмжээнд 22,391,122.2 мянган төгрөг, 2024 онд хэрэгжих 112 төсөл, арга хэмжээнд 76,919,603.2 мянган төгрөг, нийт 99,310,725.4 мянган төгрөгийн 168 төсөл, арга хэмжээг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хөрөнгө оруулалтын дансанд ташаарсан орлого 34,732.9 мянган төгрөг, төсөл, арга хэмжээнд 75,740,594.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, нийт 75,775,327.6 мянган төгрөгийн орлого орсноос, гүйцэтгэгч байгууллагад 70,525,500.3 мянган төгрөг, техник хяналтын зардалд 199,038.3 мянган төгрөг, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд 155,665.4 мянган төгрөг, захиалагчийн хяналтын зардалд 351,955.6 мянган төгрөг, техникийн нөхцөл авах зардалд 18,973.9 мянган төгрөг, газар чөлөөлөлтийн үнэлгээ хийлгэх зардалд 7,000.0 мянган төгрөг, газар чөлөөлөлтийн нөхөн олговрын зардалд 1,359,348.0 мянган төгрөг, барьцаа дансанд 3,157,846.2 мянган төгрөг, нийт 75,775,327.6 мянган төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлж, үлдэгдэлгүй тайлагнасан байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалт:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2024 оны “Дүүргийн 2024 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 26 дугаар тогтоолоор он дамжин хэрэгжих 7 төсөл, арга хэмжээний нийт 2,566,086.0 мянган төгрөг, 2024 онд хэрэгжих 4 төсөл, арга хэмжээний 3,424,655.9 мянган төгрөг, нийт 5,990,741.9 мянган төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтын дансны эхний үлдэгдэл 2,753,024.8 мянган төгрөг, тайлант онд 3,100,618.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, гүйцэтгэгч байгууллагад 3,256,960.3 мянган төгрөг, техник хяналтын зардалд 4,509.3 мянган төгрөг, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд 5,545.6 мянган төгрөг, захиалагчийн хяналтын зардалд 57,008.3 мянган төгрөг, нийт 3,324,023.5 мянган төгрөгийг олгож, барьцаа дансанд 121,068.0 мянган төгрөгийг байршуулан оны эцэст 2,408,552.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нийт барьцаа хөрөнгө: Дүүргийн барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 1,288,741.6 мянган төгрөг байснаас 3,331,143.3 мянган төгрөгийн барьцааг нэмж байршуулж, 1,193,480.6 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж, оны эцэст 3,426,404.3 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

3.6.6 ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Нийслэлийн Хан-Уул дүүрэгт Хан Уул Агро, Хан-Уул Яармаг, Тохижилт үйлчилгээний төв, Нийтлэг үйлчилгээний алба, Эко хотын тээвэр, Эко ахмадын сувилал, Зам засвар арчлалт, Хан-Эко тээвэр нийт 8 ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх ОНӨААТҮГ-уудаас 2024 онд нийт 46,872,579.0 мянган төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 2,172,991.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн харъяа байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Ё.Лхагвадулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/137 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Материаллаг байдлыг төлөвлөлтийн үе шатанд 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 294,473,389.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,417,100.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж тайлант оны зардлыг өмнөх онтой харьцуулахад 200,330,947.6 мянган төгрөг буюу 68 хувиар өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 494,804,337.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,422,065.1 мянган төгрөгөөр тус тус тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус дүүргийн харьяа байгууллагууд нь батлагдсан төсвийг хэтрүүлээгүй ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,767,264.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 19,801.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 154,562.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2,592,900.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 14 зөвлөмжийг төсвийн шууд захирагчдад хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ нь Шилэн дансны цахим хуудаст үндсэн хөрөнгө бүртгэх тухай байгууллагын даргын шийдвэрийг байршуулаагүй, Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, 15 мэдээллийг байршуулаагүй, Гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээний зардал нь таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 9,189,669.7 мянган төгрөгийн 12 гүйлгээ, зарлагын 1,419,976.2 мянган төгрөгийн 57 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шилэн дансны цахим хуудаст:

ТТЗ нь 21,501.8 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 984,157.6 мянган төгрөгийн зарлагын 7 гүйлгээ, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 5,690,257.2 мянган төгрөгийн 76 шийдвэр мэдээлээгүй;

Харьяа байгууллагуудаас:

Шилэн дансны цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ашиг сонирхлын мэдэгдэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг мэдээллийг байршуулаагүй, 3 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан; (*Эко хотын тээвэр ОНӨААТҮГ*)

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 41,419.1 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 1,196,447.3 мянган төгрөгийн 63 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2,706,050.6 мянган төгрөгийн 227 шийдвэрийг тус тус байршуулаагүй, 5,539,749.0 мянган төгрөгийн 217 гүйлгээ, 2,064,143.8 мянган төгрөгийн 82 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. (*ИТХ 5,276,362.0 мянган төгрөг, ЗДТГ 5,491,425.5 мянган төгрөг, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 241,419.1 мянган төгрөг, Хан-Уул агро ОНӨААТҮГ 221,331.7 мянган төгрөг, Хан-Уул яармаг ОНӨААТҮГ 219,349.0 мянган төгрөг, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ 40,682.5 мянган төгрөг, Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ 40,000.0 мянган төгрөг, Хан-Уул яармаг ОНӨААТҮГ 17,240.0 мянган төгрөг*)

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

1. Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд 39,840.0 мянган төгрөгийн цэцгийн үрийг сонгон шалгаруулалтгүй шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох НТАГ-2025/005/НА-СТА-ТТЗ

төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

2.Тайлант онд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээд тарьц суулгац худалдан авах 416,100.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн үнэлгээний хороо тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг тендер нээсэн өдөр эхлүүлээгүй, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах тухай мэдэгдлийг Хан-Уул дүүргийн ЗДТГ-аас хүргүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш нэг цагийн дотор тендерийг нээнэ", 23.2-т "Тендерийг нээж, дараах мэдээллийг цахим системээр зарлана", 23.2.1-т "оролцогчийн нэр", 23.2.2-т "тендерийн үнэ", 23.2.3-т "санал болгосон үнийн хөнгөлөлт", 23.2.4-т "хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ", 23.2.5-т "тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтад тендерийн баталгаа ирүүлсэн эсэх", 51 дүгээр зүйлийн 51.2-т "Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, Шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийг байршуулаагүй зөрчлийг арилгах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийслэлийн Хан-Уул дүүргийн орон нутгийн төсвийн байгууллагуудын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудитыг хийж, санхүүгийн тайлангийн аудитаар 17,398,498.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил, нийцлийн аудитын асуудлаар 24,587,945.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад залруулагдаагүй алдаа, зөрчлийг жилийн эцсийн аудитын дүнд нэгтгэн тайлагнасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудитаар нийт 1,239,006.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 26,717.3 мянган төгрөгийн 4 төлбөрийн актыг барагдуулж, 777,605.9 мянган төгрөгийн 16 албан шаардлагын хэрэгжилт 75.0 хувь, 434,683.0 мянган төгрөгийн 48 зөвлөмж 95.8 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	26,717.3	4	26,717.3	100.0
Албан шаардлага	16	777,605.9	12	542,790.5	75.0
Зөвлөмж	48	434,683.0	46	414,466.7	95.8
Нийт дүн	68	1,239,006.2	62	983,974.5	90.3

/мянган төгрөгөөр/

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй худалдан авалтын и баримт татварын цахим системд бүртгэгдээгүй, авлагыг үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулаагүй, сэлбэгийг олгохдоо техник комиссын акт үйлдээгүй, машин механизмын техникийн паспортод бичилт хийдэггүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зэрэг зөрчлийг зогсоогоогүй, давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлсэн.

Өмнөх оны аудитаар илэрсэн анхан шатны бүрдэл дутуу баримтаар мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ гаргасан зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэхээр тогтлоо. Үүнд:

- Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад олгосон урьдчилгааны гүйцэтгэлийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 12 төсвийн байгууллага, сан, зардал, 8 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 20 байгууллага, сан, зардал аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 8 байгууллага (ИТХ, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Усан спорт сургалтын төв, Соёлын ордон, Худалдан авах ажиллагааны алба), 4 сан, зардал (Байгаль хамгаалах сан, ОНХС, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал, Барьцаа хөрөнгө), 8 ОНӨААТҮГ (Хан-Уул яармаг ОНӨААТҮГ, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ, Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ, Нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан эко тээвэр ОНӨААТҮГ, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан-Уул агро ОНӨААТҮГ, Хан эко тээвэр ОНӨААТҮГ)-ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2	-	12	-
2	ОНӨААН	-	6	-	-
	Дүн	2	6	12	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” (ИТХ, ЗДТГ, Хан-уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ, Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ, Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан-Уул агро ОНӨААТҮГ), “Хязгаарлалттай” (Хан-Уул дүүргийн Хан эко тээвэр ОНӨААТҮГ, Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ) дүгнэлт өгсөн.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,046,850.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 35,186.0 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 4,904,704.1 мянган төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлж, 174,449.6 мянган төгрөгийн зөрчилд 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 468,960.1 мянган төгрөгийн 19 зөвлөмж өгсөн.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллах 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн. Үүнд:

5.2.1 Албан шаардлага

1. Дүүргийн орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас гүйцэтгэгч компаниудад банкны баталгааг үндэслэн гэрээний үнийн дүнгийн 30 хувиас илүү 3,221,781.7 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон нь Засгийн газрын Журам шинэчлэн батлах тухай 2023 оны 278 тогтоолын хавсралтын 4.8.13-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна”, Тендер шалгаруулалтын баримт бичгийн Ё.бусад ТШЗ 38.1-д “Урьдчилгаа төлбөр олгох хувь хэмжээ: гэрээний үнийн дүнгийн 30 хүртэл хувь” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын урьдчилгааг журам, тендерийн баримт бичигт заасан үнийн дүнгээр олгоогүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Хөрөнгө оруулалтын барьцааны өр төлбөрийн 421,281.5 мянган төгрөгийн үлдэгдлийн тооцоог хийж, баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж,

үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн үлдэгдлийн тооцоог хийгээгүй, баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналд тавих хяналт хангалтгүйгээс санхүүгийн тайлангийн аудитаар илэрч байгаа зөрчлийн тоо, мөнгөн дүн буурахгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн		
								Тоо	Дүн	Тоо	Дүн				
	Хан-Уул дүүргийн ТТЗ														
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	0	-												
2	Хан-Уул дүүргийн ИТХ	0	-												
3	Хан-Уул дүүргийн Хөрөнгө оруулалт	0	-												
4	Хан-Уул дүүргийн ОНХС	0	-												
5	Хан-Уул дүүргийн Барьцаа хөрөнгө	0	-												
6	Хан-Уул дүүргийн Байгаль хамгаалах сан	0	-												
7	Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба	0	-												
8	Хан-Уул дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	0	-												
9	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	0	-												
10	Хан-Уул дүүргийн Соёлын ордон	0	-												
11	Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв	0	-												
12	Хан-Уул дүүргийн Туул тосгоны ажлын алба	0	-												
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Хан-Уул Яармаг худалдааны төв ОНӨААТҮГ	1	2,372.0					1	2,372.0	1	2,372.0				
14	Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ	1	2,523.9					1	2,523.9	1	2,523.9				
15	Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ	3	1,377,476.5					3	1,377,476.5	3	1,377,476.5				
16	Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ	4	74,127.8					4	74,127.8	4	74,127.8				
17	Хан-Уул дүүргийн Хан эко тээвэр ОНӨААТҮГ	1	140,883.5					1	140,883.5	1	140,883.5				
18	Хан-Уул дүүргийн Тохжилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	2	1,158,967.0	1	19,000.0	1	19,000.0	1	1,139,967.0	2	1,158,967.0				
19	Хан-Уул агро ОНӨААТҮГ	0	-												
20	Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	1	290,500.0					1	290,500.0	1	290,500.0				
	ОНӨААТҮГ-ын дүн	13	3,046,850.7	1	19,000.0	12	3,027,850.7	13	3,046,850.7	0	0	0	0	0	0
	НИЙТ ДҮН	13	3,046,850.7	1	19,000.0	12	3,027,850.7	11	3,046,850.7	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил				Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага							
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
	Хан-Уул дүүргийн ТТЗ	3	3,643,063.2			2	3,643,063.2	1	-						
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	4	410,124.7	1	6,745.9	1	122,500.0	2	280,878.8						
2	Хан-Уул дүүргийн ИТХ	4	71,569.3	2	24,829.3			2	46,740.0						
3	Хан-Уул дүүргийн Хөрөнгө оруулалт	0	-												
4	Хан-Уул дүүргийн ОНХС	0	-												
5	Хан-Уул дүүргийн Барьцаа хөрөнгө	0	-												
6	Хан-Уул дүүргийн Байгаль хамгаалах сан	0	-												
7	Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба	0	-												
8	Хан-Уул дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	0	-												
9	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	0	-												
10	Хан-Уул дүүргийн Соёлын ордон	0	-												
11	Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв	3	65,750.0					3	65,750.0						
12	Хан-Уул дүүргийн Туул тосгоны ажлын алба	0	-												
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	14	4,190,507.2	3	31,575.2	3	3,765,563.2	8	393,368.8	-	-				
13	Хан-Уул Яармаг худалдааны төв ОНӨААТҮГ	2	23,641.0					2	23,641.0						
14	Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ	1	4,928.1					1	4,928.1						
15	Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ	2	124,704.5					1							
16	Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ	3	1,306.0	1	384.6			2	921.4	1	124,704.5				
17	Хан-Уул дүүргийн Хан эко тээвэр ОНӨААТҮГ	1	388,051.9			1	388,051.9								
18	Хан-Уул дүүргийн Тохжилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	5	14,778.6			2	4,015.5	2	412.6	1	10,350.5				
19	Хан-Уул агро ОНӨААТҮГ	5	88,309.0	3	3,226.2			1	45,688.2	1	39,394.6				
20	Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	6	747,073.5			4	747,073.5	2							
	ОНӨААТҮГ-ын дүн	25	1,392,790.6	4	3,610.8	7	1,139,140.9	11	75,591.3	3	174,449.6				
										0	0				

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

НИЙТ ДҮН			39	5,583,299.8	7	35,186.0	10	4,904,704.1	19	468,960.1	3	174,449.6	-	-
----------	--	--	----	-------------	---	----------	----	-------------	----	-----------	---	-----------	---	---

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хан-Уул дүүргийн ТТЗ	1	6,695,916.6							1	6,695,916.6				
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	4	6,369,607.8							4	6,369,607.8				
2	Хан-Уул дүүргийн ИТХ	5	6,278,396.5					2	5,430,924.2	3	847,472.3				
3	Хан-Уул дүүргийн Хөрөнгө оруулалт	0	-												
4	Хан-Уул дүүргийн ОНХС	0	-												
5	Хан-Уул дүүргийн Барьцаа хөрөнгө	0	-												
6	Хан-Уул дүүргийн Байгаль хамгаалах сан	0	-												
7	Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба	2	11,788.3							2	11,788.3				
8	Хан-Уул дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	2	25,839.0							2	25,839.0				
9	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	49,906.7							1	49,906.7				
10	Хан-Уул дүүргийн Соёлын ордон	2	113,454.1							2	113,454.1				
11	Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв	2	93,672.6							2	93,672.6				
12	Хан-Уул дүүргийн Туул тосгоны ажлын алба	3	299,807.9							3	299,807.9				
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	22	19,938,389.5	-	-	2	5,430,924.2	20	14,507,465.3	-	-				
13	Хан-Уул Яармаг худалдааны төв ОНӨААТҮГ	3	255,515.0							3	255,515.0				
14	Хан-Уул дүүргийн Эко ажмадын сувилал ОНӨААТҮГ	3	143,362.7							3	143,362.7				
15	Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ	0	-												
16	Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ	2	47,849.6							2	47,849.6				
17	Хан-Уул дүүргийн Хан эко тээвэр ОНӨААТҮГ	1	92,541.5							1	92,541.5				
18	Хан-Уул дүүргийн Тохжилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	4	720,717.9					1	416,100.0	2	264,777.9			1	39,840.0
19	Хан-Уул агро ОНӨААТҮГ	2	225,081.7	1	3,750.0									1	221,331.7
20	Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	3	43,472.7	1	16,051.2			1		1	27,421.5				
	ОНӨААТҮГ-ын дүн	18	1,528,541.1	2	19,801.2	2	416,100.0	2	416,100.0	12	831,468.2			2	261,171.7
	НИЙТ ДҮН	40	21,466,930.6	2	19,801	4	5,847,024.2	32	15,338,933.5	2	261,171.7			2	261,171.7